Авлага дансны үлдэгдэл 20,000.0 мянган төгрөг болж 13,897.5 мянган төгрөгөөр өссөн нь Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд Сүмбэр сумын Таван буянт ирээдүй хөгжил ХХК-д хөрөнгө оруулалтын санхүүжилт хийсэн ч Ковид-19 цар тахлын халдварын улмаас хөл хорио тогтоосноос барилгын материалыг УБ-хотоос татах боломжгүй болж, барилгын ажил дуусаагүй зогссоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд  2020 онд үүссэн,  байгууллагаас 20,000.0 мянган төгрөгийн авлага байна. Нийт авлагаас  барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 146,378.1 мянган төгрөг болж 46,397.6 мянган төгрөгөөр өссөн нь МЭЕГ-аас ирсэн шүлхийн вакцин, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, ариутгалын бодис авснаас шалтгаалжээ.

Энэ нь бараа материалын дансанд хэрэглэгдэх ашиглалтгүй хөрөнгө байгаа нь бараа материалын нөөцтэй байгаа харагдуулж байна.

Оны эцэст 9,000.0 мянган төгрөгийн халдвар хамгааллын хувцас иж бүрдэл, хлорын шохой, суперкилл, автомакс зэрэг худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Ковид-19 цар тахал гарсантай холбоотой нөөц бүрдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,440,929.1 мянган төгрөг болж 1,053,031.7 мянган төгрөгөөр өссөн нь бүтцийн өөрчлөлтөөр Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2020.12.02-ны өдрийн А/17 тоот тушаалаар ХХААГ-ын балансаас МЭГ-ын балансад шилжүүлэх шийдвэрээр үндсэн хөрөнгө барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, газрыг бүртгэж авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 14,218.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,794,935.7 мянган төгрөгөөр хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө хасагдаагүй байна.

Биет бус хөрөнгө Төв аймгийн Засаг даргын 2020.04.20-ны өдрийн А/246 тоот захирамжаар газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай ХХААГ-ын 5344 м2 газраас 2205 м2 газрын эрхийг шилжүүлснээр 55,125.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0 байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,607,307.2 мянган төгрөг болж 1,113,326.9 мянган төгрөгөөр өссөн нь ХХААГ-ын балансаас үндсэн хөрөнгө шилжин ирснээс шалтгаалжээ.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 385,077.9 мянган төгрөгөөр буюу 111,7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 234,268.6 мянган төгрөгөөр буюу 7,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, нормативт зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан гүйлгээ гараагүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,428,333.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,428,333.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 496,444.9 мянган төгрөгөөр бууруулж 931,888.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс цалингийн зардал өссөн нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний

төлбөр хураамжийн зардлаас Мал эмнэлгийн тасгийн цалин төлөвлөгдөж байсантай холбоотой материаллаг өөрчлөлт гарсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 903,742.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 901,742.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 2,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 901,742.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2,015.2 мянган төгрөг, нийт 903,742.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 896,546.6 мянган төгрөгийг зарцуулж, 7,211.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 896,546.6 мянган төгрөг буюу 99,15 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлыг 1,494.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,638.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардал 1,359.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн 3 арга хэмжээ 2,926.1 мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн бодлого хөтөлбөрийн 2 арга хэмжээ 4,285.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

| Хөтөлбөр арга хэмжээний нэр | | Хэмнэгдсэн зардал |
|---|---|---|
| 70801 | Мал аж ахуйг хөгжүүлэх | 2,926,132.50 |
| 82502 | Мал эмнэлгийн үйлчилгээ | 1,983,150.50 |
| 82508 | Малын өвчний лабораторийн онош | 25,920.00 |
| 82542 | Монгол мал хөтөлбөр | 917,062.00 |
| 70805 | Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого | 4,285,174.78 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 4,164,974.78 |
| 80227 | Лабораторийн итгэмжлэл | 120,200.00 |
| Зардлын дүн | | 7,211,307.28 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 352,217.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 352,217.4 мянган төгрөгийг зарцуулж, нэмэлт санхүүжилтийн данснаас үлдэгдэлгүй байна

| № | Зардлын нэр | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | Шатахуун | 4,332,780.00 |
| 2 | Томилолт | 16,525,000.00 |
| 3 | Шүлхий, бруцеллёз, галзуу, боом, томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үйлчилгээний хөлс | 311,359,590.00 |
| 4 | Швейцарын хамтын ажиллагаатай байгуулсан № 81061564 гэрээг хэрэгжүүлэх барилгын ажлын зардал | 20,000,000.00 |
| | Нэмэлт санхүүжилтийн зардлын дүн | 352,217,370.00 |

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

Аудитаар шилэн дансны мэдээллийг үнэн зөв бодитой мэдээлсэн эсэхийг шалгахад төсвийн хэтрэлт хэмнэлтийн дүнг гаргаагүй тайлбар шалтгааныг бичээгүй, жилийн төлөвлөгөөг зарим сард мэдээлээгүй ХАА-ны төлөвлөгөөг батлагдсан маягтаар хийгээгүй, PDF файлаар оруулаагүй, хөрөнгийн зардал төлөвлөгөө гүйцэтгэл мэдээлэл байхгүй, бичиг хэрэг, шатахуун зэрэг худалдан авалт хийсэн байхад урсгал зардалд тендерийн ерөнхий мэдээлэлгүй, санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн биелэлт албан тоотоор бус гарын үсэг тамгагүй албажаагүй мэдээлэл үг үсгийн алдаатай, Хувийн мал эмнэлгийн газарт олгож байгаа үйлчилгээний хөлсний шийдвэр байхгүй, 5,0 сая дээш орлого зарлагын хувьд шийдвэр бүрэн бус, зарлагын 2 гүйлгээ орлогын 1 гүйлгээ дутуу, 5,0 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлэх байдал хангалтгүй 93 гүйлгээг дутуу, худалдан авах ажиллагааны тайлан мэдээлэгдээгүй, хөрөнгөтэй холбоотой 8 шийдвэр дутуу, худалдан авахтай холбоотой 10 гэрээ байхгүй, Улсын байцаагчдын албан томилолтоор суманд хяналт шалгалтаар ажилласан талаар шалгалтын үр дүнгийн талаар мэдээлэлгүй, Санхүүгийн хяналт аудитын албаны шалгалтын дүнг мэдээлээгүй, байгууллагын дотоод хяналтын тайланг мэдээлээгүй зэрэг алдаа зөрчил илэрлээ.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 201,104.9 мянган төгрөгийн зөрчилд 201,104.9 мянган төгрөгийн зөвлөмж өгч зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | | | | | |
| Албан шаардлага | - | - | | | | | |
| Зөвлөмж | 5 | 201,104.9 | 5 | 201,104.9 | - | - | - |
| Нийт дүн | 5 | 201,104.9 | 5 | 201,104.9 | | | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 489,107.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 461,617.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 479.9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 27,011.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төв аймгийн Засаг даргын 2020.04.20-ны өдрийн А/246 тоот захирамжаар газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай ХХААГ-ын 5344 м2 газраас 2205 м2

газрын эрхийг шилжүүлснээр 55,125.0 мянган төгрөгөөр газрын эзэмших эрхийг 55,125.0 мянган төгрөгөөр бүртгэж залруулсан.

2. Тусгай зориулалтын бараа материалд 5 нэрийн 70 тооны 17,047.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг залруулан бүртгэсэн.
3. Эхний ирүүлсэн санхүүгийн тайланд бараа материалын зарлагыг бүрэн тайлагнаагүйг 389,444.8 мянган төгрөгөөр залруулав.

## Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 27,490.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 479.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад даргын томилсон хоногоос илүү томилолтын зардал олгосон, сахилгын шийтгэлийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2 сарын цалингаас дутуу суутгасан зэрэг 479.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн аудитын “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

## Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 27,490.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 27,011.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хувийн мал эмнэлэгт үйлчилгээний хөлс өгч байгаа энэ асуудлын гүйцэтгэлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.*Авлагын данстай холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:* Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд Сүмбэр сумын Таван буянт ирээдүй хөгжил ХХК-д хөрөнгө оруулалтын санхүүжилт хийсэн ч гэрээний 3.2.3-д 2020.12.20-ны дотор МЭЕГ-ын Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газарт ирүүлэх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс авлага материаллаг дүнгээр өссөн байна.

*1.2 Эрсдэл:* Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байх

*1.3 Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн төсвийн зарчмыг хэрэгжүүлэх, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж зөрчлийг давтан гаргахгүй байх

*1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* байхгүй

*2.Дотоод хяналттай холбоотой асуудал*

*2.1 Илрүүлэлт:* 2019 оны жилийн эцсийн тайлангаар өглөггүй тайлагнасан байхад Хашхан ХХК-аас 2019 оны 12 сард 9,960.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил авснаас үлдэгдэл 2,560.0 мянган төгрөгийн тавилгын үнэ төлсөн, 2019 оны 4,451.0 мянган төгрөгийн томилолт олгосон байна.

*2.2. Эрсдэл:* Санхүүгийн тайланд өглөг дутуу бүртгэгдсэн байх

*2.3. Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг мөрдөж цаашид зөрчлийн давтан гаргахгүй байх

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* байхгүй

*3.Шилэн данстай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:*

1. Төсвийн хэтрэлт хэмнэлтийн дүнг гаргаагүй тайлбар шалтгааныг бичээгүй, 1,2,3,4,5,6 сар болон 1, 3-р улиралд жилийн төлөвлөгөө байхгүй, 10 сар төлөвлөгөө гүйцэтгэлээс бага, жилийн эцэст мэдээлээгүй
2. 5,0 сая дээш орлого зарлагын хувьд 10 сард 20.0 сая төгрөгийн зарлагын шийдвэргүй, 12 сард 9.0 сая төгрөг, 15.9 сая төгрөг, 62.3 сая төгрөг, 6.8 сая төгрөг тус тус мэдээлсэн ч баримтгүй, зарлагын 2 гүйлгээ орлогын 1 гүйлгээ дутуу мэдээлсэн байна.
3. ХАА-ны төлөвлөгөөг батлагдсан маягтаар хийгээгүй PDF файлаар оруулаагүй,
4. Хөрөнгийн зардал төлөвлөгөө гүйцэтгэл мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байхад санхүүгийн тайлангаар 14.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
5. Бичиг хэрэг 11.8 сая төгрөг, Шатахуун 24.9 сая төгрөг, Холбоо 8.6 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байхад урсгал зардалд тендерийн ерөнхий мэдээллийг мэдээлээгүй.

6. 5,0 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлэх байдал хангалтгүй 93 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авах ажиллагааны тайлан мэдээлэгдээгүй
7. Хөрөнгөтэй холбоотой 8 шийдвэр дутуу, худалдан авалттай холбоотой 10 гэрээ мэдээлэгдээгүй.
8. Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн биелэлт албан тоотоор бус гарын үсэг тамгагүй албажаагүй мэдээлэл үг үсгийн алдаатай,
9. Үйлчилгээний хөлс хувийн Мал эмнэлгийн газарт олгож байгаа тул үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон ямар нэгэн шийдвэр байхгүй,
10. Хяналт шалгалтын бусад мэдээлэлд Улсын байцаагч нараас албан томилолтоор суманд хяналт шалгалтаар ажилласан талаар шалгалтын үр дүнгийн талаар ямар ч мэдээлэл байхгүй, Мөн Санхүүгийн хяналт шалгалтаас хийсэн дүнг мэдээлээгүй, Байгууллагын дотоод хяналтын дүн тайланг мэдээлээгүй зэрэг алдаа зөрчил илэрлээ.

*3.2. Эрсдэл:*Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байх

*3.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн шилэн дансны зарчим 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 4.1.4-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэсэн заалтыг мөрдөж зөрчлийг давтан гаргахгүй байх

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.06.05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 он | | | ТӨА-2021-214-СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Төв аймгийн Мал эмнэлгийн газар | Мянган төгрөг |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулж мэдээлээгүй | 0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан бодогч | Б.Болдбаатар<br>Б.Санчир |
| 2 | Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийж гэрээний заалтыг хэрэгжээгүй. | 20,000.0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан бодогч | Б.Болдбаатар<br>Б.Санчир |
| 3 | 2019 оны жилийн эцсийн тайлангаар өглөггүй тайлагнасан байхад тавилгын үнэ төлсөн, томилолт олгосон. | 7,011.0 | Зөвлөмж | Дарга<br>Нягтлан бодогч | Б.Болдбаатар<br>Б.Санчир |
| 4 | Томилолт илүү олгосон, сахилгын шийтгэлийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2 сарын цалингаас дутуу суутгасан. | 479.9 | Төлбөрийн акт | Дарга<br>Нягтлан бодогч | Б.Болдбаатар<br>Б.Санчир |
| | **ДҮН** | **27,490.9** | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** **Ц.ХИШИГЖАРГАЛ**

**АУДИТЫН МЕНЕЖЕР** **О.АМАРЖАРГАЛ**

**БЭЛТГЭСЭН:**

**АУДИТОР** **Ц.САРАНЧИМЭГ**

**2021.02.17**

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2021.02.23 № 0/43
танай ______ -ны № ______ -т

ТӨВ АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БОЛДБААТАР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D 2021/2021 он/ALBAN BICHIG

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

Огноо: 2021.02.17

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

| Аудитын код: | ТӨА-2021-214-СТА-ТШЗ | Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр: | Төв аймгийн Мал эмнэлгийн газар |
|---|---|---|---|
| Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр: | Төв аймаг дахь Төрийн аудитын газар | Аудит хийсэн баг, албан тушаалтан | Төв аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Ц.Саранчимэг |
| Аудитын нэр: | Төв аймгийн Мал эмнэлгийн газар 2020 оны санхүүгийн тайлангийн аудит | | |

**Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл**

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | | Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудит хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт | Итгэл үзүүлсэн | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Төв аймгийн Мал эмнэлгийн газар | 1 | + | | | | + | | | |
| | ДҮН | 1 | + | | | | + | | | |

**Гурав. Аудитын үр дүн**

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Зөвлөмж | Төлбөрийн акт | Албан шаардлага | Залруулсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төв аймгийн Мал эмнэлгийн газар | 7 | 489,107.9 | 27,490.9 | - | - | 461,617.0 |
| | ДҮН | 7 | 489,107.9 | 27,490.9 | - | - | 461,617.0 |

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

**Алдаа, зөрчилтэй асуудал 1**

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад даргын томилсон хоногоос илүү томилолтын зардал олгосон, сахилгын шийтгэлийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2 сарын цалингаас дутуу суутгасан зэрэг 479.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт бичигдсэн.

**Алдаа, зөрчилтэй асуудал 2**

Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хүрээнд Сүмбэр сумын Таван буянт ирээдүй хөгжил ХХК-д хөрөнгө оруулалтын санхүүжилт хийсэн ч гэрээний 3.2.3-д 2020 оны 12 дугаар сарын 20-ны дотор МЭЕГ-ын Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газарт ирүүлэх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс авлага материаллаг дүнгээр өссөн байна.

Шийдвэрлэлт: Зөвлөмж өгсөн.

**Алдаа, зөрчилтэй асуудал 3**

2019 оны жилийн эцсийн тайлангаар өглөггүй тайлагнасан байхад Хашхан ХХК-аас 2019 оны 12 сард 9960.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил авснаас үлдэгдэл 2560.0 мянган төгрөгийн тавилга үнэ төлсөн , 2019 оны 4451.0 мянган төгрөгийн томилолт олгосон байна.

Шийдвэрлэлт: Зөвлөмж өгсөн.

**Алдаа, зөрчилтэй асуудал 4**

1.Төсвийн хэтрэлт хэмнэлтийн дүнг гаргаагүй тайлбар шалтгааныг бичээгүй, 1,2,3,4,5,6 сар болон 1, 3-р улиралд жилийн төлөвлөгөө байхгүй, 10 сар төлөвлөгөө гүйцэтгэлээс бага, жилийн эцэст мэдээлээгүй
2. 5,0 сая дээш орлого зарлагын хувьд 10 сард 20.0 сая төгрөгийн зарлагын шийдвэргүй, 12 сард 9.0 сая төгрөг, 15.9 сая төгрөг, 62.3 сая төгрөг, 6.8 сая төгрөг тус тус мэдээлсэн ч баримтгүй, зарлагын 2 гүйлгээ орлогын 1 гүйлгээ дутуу мэдээлсэн байна.
3.ХАА-ны төлөвлөгөөг батлагдсан маягтаар хийгээгүй PDF файлаар оруулаагүй,
4.Хөрөнгийн зардал төлөвлөгөө гүйцэтгэл мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байхад санхүүгийн тайлангаар 14.1 сая төгрөгийн ҮХ бэлтгэсэн.
5. Бичиг хэрэг 11.8 сая төгрөг, Шатахуун 24.9 сая төгрөг, Холбоо 8.6 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байхад урсгал зардалд тендерийн ерөнхий мэдээллийг мэдээлээгүй.
6. 5,0 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлэх байдал хангалтгүй 93 гүйлгээг мэдээлээгүй, ХАА-ны тайлан мэдээлэгдээгүй
7. Хөрөнгөтэй холбоотой 8 шийдвэр дутуу, худалдан авалттай холбоотой 10 гэрээ мэдээлэгдээгүй.
8. Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн биелэлт албан тоотоор бус гарын үсэг тамгагүй албажаагүй мэдээлэл үг үсгийн алдаатай,
✓9. Үйлчилгээний хөлс хувийн Мал эмнэлгийн газарт олгож байгаа тул үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон ямар нэгэн шийдвэр байхгүй,
10. Хяналт шалгалтын бусад мэдээлэлд Улсын байцаагч нараас албан томилолтоор суманд хяналт шалгалтаар ажилласан талаар шалгалтын үр дүнгийн талаар ямар ч мэдээлэл байхгүй, Мөн Санхүүгийн хяналт шалгалтаас хийсэн дүнг мэдээлээгүй, Байгууллагын дотоод хяналтын дүн тайланг мэдээлээгүй зэрэг алдаа зөрчил илэрлээ.

Шийдвэрлэлт: Зөвлөмж өгсөн.

**4. Аудитын санал дүгнэлтийн үндэслэл**:

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул **зөрчилгүй** санал дүгнэлт гаргаж байна.

**Тав. Баталгаажуулалт**

**Тайлангийн хураангуй бэлтгэсэн:**

**Аудитор** **Ц.Саранчимэг**

**Анхан шатны чанарын хяналт хийсэн:**

**Аудитын менежер** **О.Амаржаргал**

**Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:**

**Тэргүүлэх аудитор** **Ц.Хишигжаргал**

**ТӨВ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2021 оны 02 сарын 24 өдөр Дугаар 01-А1970403-ТӨА-2021/214/ СТН-ТШ3 Зуунмод

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад сахилгын шийтгэлийг хэрэгжүүлээгүйгээс дутуу суутгасан, албан томилолтын хоногийг илүү тооцсон зэрэг зөрчил илэрч нийт 479.9 мянган төгрөгийг цалин, томилолтын зардал илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" тохиолдолд төлбөрийн акт тогтооно гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төв аймгийн Мал эмнэлгийн газрын илүү олгосон томилолт, дутуу суутгасан төлбөр 479.9 мянган төгрөгийг Төв аймгийн Төрийн сан банкин дахь Тө.Хүү торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021.05.01-ний дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төв аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Б.Болдбаатар, нягтлан бодогч Б.Санчир нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

*Төв аймаг дахь Төрийн аудитын газрын*
*аудитор* Ц.Саранчимэг

4117144522
НЮА0064 9060464

[1] Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

01-Н19704О3-ТОА-2021/214) СТА-ТШ 3
...р актны хавсралт

| № | Нэр | Огноо | Авсан томилолт | Илүү олгосон томилолт | Дутуу суутгасан арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | У.Дэнсмаа | 2020.02.18 | 84,000.00 | 14,000.00 | |
| 2 | Л.Цогтбаяр | 2020.02.18 | 70,000.00 | 14,000.00 | |
| 3 | Г.Гэрэлтуяа | 2020.02.18 | 153,000.00 | 14,000.00 | |
| 4 | Ч.Эрдэнэбат | 2020.04.23 | 53,000.00 | 38,500.00 | |
| 5 | О.Бүрэнжаргал | 2020.10.23 | 93,000.00 | 12,000.00 | |
| 6 | Б.Бужинлхам | 2020.10.06 | 185,500.00 | 26,500.00 | |
| 7 | Г.Гэрэлтуяа | 2020.10.06 | 212,000.00 | 26,500.00 | |
| 8 | Нийт дүн | 0 | 850,500.00 | 145,500.00 | |
| 9 | П.Батаа | | | | 334,438.00 |
| | Нийт дүн | | | 145,500.00 | 334,438.00 |